



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 62

Мандалговь

Нээлттэй аймаг хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арванхоёрдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөтөлбөр, “Шинэ сэргэлтийн бодлого”-ийн хүрээнд шилжин ирэгсдийг дэмжих “Нээлттэй аймаг” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай

2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган төлөвлөгөө боловсруулан баталж, шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсөв, олон улсын байгууллагын хандив, тусламж, төсөл, хөтөлбөрт тусган хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ш.Энхсүх)-д даалгасугай.

ДАРГА  С.ОД-ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн
62 дугаар тогтоолын хавсралт

"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
"Шинэ сэргэлтийн бодлого"-ийн хүрээнд шилжин ирэгсдийг
дэмжих "Нээлттэй Дундговь аймаг" хөтөлбөр

Нэг. Нийтлэг үндэслэл

"Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого"-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд шилжин ирэгсдийг дэмжих, ялангуяа Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, орон нутагт ажиллах мэргэжилтэй боловсон хүчнийг нэмэгдүүлэх, эрүүл мэнд, боловсролын чанарыг дээшлүүлэх, шинээр ирж суурьших аж ахуй нэгжийг дэмжин орон нутгийн бие даан хөгжих нөхцөлийг бүрдүүлэх шаардлага бий болж байна.

Хоёр. Хөтөлбөрийн Зорилго

Хүн амын тоог нэмэгдүүлж, өрсөлдөх чадварыг бий болгох, дутагдалтай боловсон хүчнийг орон нутагтаа татан ажиллуулах, эрүүл мэнд, боловсролын чанарыг дээшлүүлэх, шилжин ирж буй аж ахуй нэгж, иргэдийг бодлогоор дэмжихэд оршино.

Гурав. Хөтөлбөрийн зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

Зорилт-1. Алсын хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд аймгийн хүн амын тоог 10 хувиар нэмэгдүүлнэ.

1.1. Аймаг, сум орон нутгаа сурталчилсан "Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг Улаанбаатар хотноо зохион байгуулах.

1.2. Шилжилт хөдөлгөөн, аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгоход иргэд, олон нийт, аж ахуйн нэгжийн саналыг тусган хүргүүлэх.

1.3. "Аймгийн хөрөнгө оруулагчдын чуулган"-ыг зохион байгуулах

1.4. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй орон нутаг руу чиглэх шилжилт хөдөлгөөний бодлого, дэмжлэг, урамшууллыг олон нийтэд таниулан сурталчлах, аймаг, суманд шилжин суурьших хүсэлтэй иргэдэд мэдээлэл өгөх.

1.5. Орон нутагт шилжин суурьшиж, амьдарч байгаа кейсүүдийг сурталчлан контент болгон нэвтрүүлэх.

Зорилт 2: Шинэ нутаг-шинэ боломж ажиллах, амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

2.1. Аймгийн цахилгаан, дулаан, цэвэр, бохир зэрэг инженерийн дэд бүтцийн тооцоо, судалгааг нарийвчлан гаргах.

2.2. Дундговь аймгийн "Хүний нөөцийг дэмжих" хөтөлбөртэй уялдуулан их, дээд сургууль, МСҮТ-ийг шинээр төгсч буй оюутан залууст чиглэсэн "НУТГАА ЗОРЪЯ" өдөрлөгийг зохион байгуулах

2.3. Шаардлагатай эмч, сувилагч, багш нарыг аймаг, сумандаа татах хөдөлгөөнийг өрнүүлэх

2.4. Сумдад ашиглалтгүй байгаа барилгуудыг засварлан орон сууц, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр ашиглах.

Зорилт 3: Орон нутагт хэрэгжиж буй Олон улсын болон дотоодын төсөл хөтөлбөрийг нэмэгдүүлнэ.

3.1. Гипсэн хавтан, шохойн блокны үйлдвэр, Онги голыг түшиглэсэн малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн үйлдвэр байгуулах, Олон Улсын тээвэр, логистикийн төв байгуулах аж ахуйн нэгж болон шилжин ирж буй үйлдвэр эрхлэгчдийг дэмжин ажиллах.

3.2. Дэд бүтэцжүүлэх ажлыг зохион байгуулж орон сууцжуулах ажлыг дэмжих.

3.3. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бэлтгэн нийлүүлэх, боловсруулах чиглэлээр шинээр байгуулагдах үйлдвэрийг татвараас тодорхой хувиар чөлөөлөх.

Зорилт 4: Иргэний нийгмийн байгууллага, Төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулна.

4.1. Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн холбоод, ТББ, Иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, хамтран ажиллах, төрийн зарим чиг үүргийг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлэх.

4.2. “Дундговио ногооруульа” хөтөлбөртэй уялдуулан ногоон байгууламжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар зорин ирж буй аж ахуйн нэгж, ТББ, иргэдийг дэмжин ажиллах.

4.3. Сургалт, судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, иргэний нийгмийн байгууллагуудыг чадавхжуулах.

4.4. Хэлэлцүүлэг зохион байгуулах, хэвлэл мэдээллийн сувгаар нэвтрүүлэг бэлтгэх байдлаар иргэний нийгмийн байгууллагуудын үүрэг оролцоог нэмэгдүүлэх.

4.5. Улаанбаатар дахь аймаг, сумын нутгийн зөвлөл дээр иргэдийг мэдээллээр хангах төлөөлөгчийг томилон ажиллуулах.

Тав . Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

2022 оны 12 дугаар сараас 2024 оны 12 дугаар сар

Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжилт, зохион байгуулалт

5.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг гарган аймгийн Засаг даргаар батлуулна.

5.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг улирал бүр тооцож аймгийн Засаг даргын зөвлөлд ажлын хэсгийн дарга танилцуулна.

Долоо.Хөрөнгийн эх үүсвэр, санхүүжилт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

- 5.1 Улсын төсөв
 - 5.2 Орон нутгийн төсөв
 - 5.3 Олон улсын байгууллагын хандив, тусламж, төсөл, хөтөлбөрийн хөрөнгө
 - 5.4 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хандив, тусламж
- оруулалт

Найм . Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүн гарсан байна.

- 7.1 Аймгийн хүн амын тоо 10 хувиар өссөн байх
- 7.2 Эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдсэн байх
- 7.3 Боловсролын чанар хүртээмж нэмэгдсэн байх
- 7.4 Иргэдийн дундаж орлого нэмэгдсэн байх
- 7.5 Аймгийн эдийн засгийн өрсөлдөх чадвар нэмэгдсэн байх

БОЛОВСРУУЛСАН: ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСЭГ